

**“HI-RAY 10 V80 ГЕНЕРАТОР /HS9075i төхөөрөмжийн рентген генератор”  
НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН  
БАРИМТ БИЧИГ**

Тендер шалгаруулалт  
гэрээний нэр:

Тендерийн дугаар:

**“Hi-ray 10 v80 генератор /hs9075i төхөөрөмжийн  
рентген генератор”** нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон  
шалгаруулах тендер  
ИНЕГ/УЗТО/ТББ/Б-04/20

Улаанбаатар 2020 он

## **Нэг. УНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

2020.09.07

*Иргэний нисэхийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бухий тендерт оролцогчдоос “Higray 10 v80 генератор /hs9075i төхөөрөмжийн рентген генератор” нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер ИНЕГ/УЗТО/ТББ/Б-04/20-т цахим үнийн санал ирүүлэхийг урьж байна.*

1. Унийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Унийн саналыг **2020 оны 09-р сарын 15-ны 08.00 цаг**-аас өмнө Засгийн газрын худалдан авах цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хуудсанд цахимаар ирүүлиэ.

Унийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 09-р сарын 15-ны 08.30 цагт** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар болон [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хуудаснаас авч болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Буянт-Ухаа,  
Иргэний нисэхийн ерөнхий газар  
Худалдан авах ажиллагааны тасаг. 108 тоот.  
Утас : 71282163*

## **Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- |  |  |
|--|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх-/д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.  |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт               | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.   |
| 3. Тендерийн иж бүрдэл                           | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:<br>(а) Унийн санал;<br>(б) Унийн болон нийлүүлэлтийн хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]   |
| 4. Тогтмол үнэ                                   | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.   |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.<br>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.  |
| 6. Унийн саналын хүчинтэй байх хугацаа           | 6.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.<br>6.2. Тендерийн хүчинтэй байх хугацаа нь хуульд заасан хүчинтэй байх хугацаанаас богино байх тохиолдолд захиалагч түүнийг үндсэн шаардлага хангагүй тендер гэж үзэж татгалзана.   |
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх            | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл      | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.  |

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт									
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн 1 жилийн /2019 он/ санхүүгийн тайлан ирүүлэх. /Аудитаар баталгаажуулсан байх./</p> <p>2. Сүүлийн 1 жилийн / 2019/ ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл ирүүлэх.</p> <p>3. Сүүлийн 1 жилийн /2019 оны борлуулалтын орлогын нийлбэр нь төсөвт өртгийн 100 хувиас багагүй байна./</p> <p>4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх.</p> <p>5. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх.</p> <p>6. Татварын албаны тодорхойлолт ирүүлэх. /Татварын өр төлбөргүй болохыг нотлох цахим тодорхойлолт ирүүлэх/</p> <p>7. Бараа нийлүүлэх хуваарийг маягтын дагуу ирүүлэх.</p> <p>8. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ.</p> <p>9. Тендерийн хэл нь <i>Зөвхөн Монгол хэл байна</i>.</p> <p><i>Харин техникийн шаардлагын гарын авлага болон техникийн үзүүлэлтийг тусгасан бичиг баримтыг монгол болон англи хэл дээр байна. Техникийн тодорхойлолтын нийцлийг доорх хүснэгтийн дагуу бэлтгэн ирүүлэх Үүнд:</i></p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th align="center"><i>№</i></th><th align="center"><i>Техникийн тодорхойлолтын шаардлагууд</i></th><th align="center"><i>Санал ирүүлж буй компанийн нийцэж буйг нотлосон заалт</i></th></tr> </thead> <tbody> <tr> <td align="center"><i>1</i></td><td align="center"><i>1.</i></td><td align="center"><i>Гарын авлагын ....,...д гэх мэт</i></td></tr> <tr> <td align="center"><i>2</i></td><td align="center"><i>2.</i></td><td></td></tr> </tbody> </table> <p><i>Гарын авлагын бичиг баримтаар нотлогдохгүй бол шаардлагад нийцээгүй гэж үзнэ.</i></p> <p><i>Харин Тендерийн материалд ирүүлсэн гадаад хэл дээрх албан ёсны бичиг баримтыг Монгол хэл рүү баталгаат орчуулгаар орчуулж ирүүлэх шаардлагатай. Ирүүлээгүй тохиолдолд шаардлага хангахгүй гэж үзнэ.</i></p>	<i>№</i>	<i>Техникийн тодорхойлолтын шаардлагууд</i>	<i>Санал ирүүлж буй компанийн нийцэж буйг нотлосон заалт</i>	<i>1</i>	<i>1.</i>	<i>Гарын авлагын ....,...д гэх мэт</i>	<i>2</i>	<i>2.</i>	
<i>№</i>	<i>Техникийн тодорхойлолтын шаардлагууд</i>	<i>Санал ирүүлж буй компанийн нийцэж буйг нотлосон заалт</i>								
<i>1</i>	<i>1.</i>	<i>Гарын авлагын ....,...д гэх мэт</i>								
<i>2</i>	<i>2.</i>									
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: <i>Тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хуудсаар цахимаар ирүүлэх.</i></p> <p><b>Огноо:</b> 2020 оны 09-р сарын 15-ны өдөр <b>Цаг:</b> 08 цаг 00 минут</p>									
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: <i>Байгууллагын хаяг: Хан-Уул дүүрэг 21-р хороо, Иргэний нисэхийн өрөөний газар. Худалдан авах ажиллагааны тасаг.</i></p> <p><b>Давхар болон өрөөний дугаар:</b> 1 давхар 108 тоот.</p> <p><b>Огноо:</b> 2020 оны 09-р сарын 15-ны өдөр <b>Цаг:</b> 08 цаг 30 минут</p>									
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаараас бүрдэнэ: <b>“Hi-ray 10 v80 генератор /hs9075i төхөөрөмжийн рентген генератор”</b> нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер ИНЕГ/УЗТО/ТББ/Б-04/20</p>									

**“HI-RAY 10 V80 ГЕНЕРАТОР /HS9075I ТӨХӨӨРӨМЖИЙН РЕНТГЕН  
ГЕНЕРАТОР” ТЕХНИКИЙН ШААРДЛАГА**

№	Нэр	Рентген цацрагийн генератор
1	Хэмжих нэгж	ширхэг
2	Тоо хэмжээ	1
3	Хэрэглээ зориулалт	“Буянт Ухаа” дахь ОУНБ-ын аюулгүй байдлын үзлэгт
4	Ашиглалт	Рентген цацрагийн генератор нь шинэ, ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ хийх шаардлагагүй, Heimann HI-SCAN 9075HR төхөөрөмжид шууд ашиглах боломжтой байх шаардлагатай.
5	Чанар түвшин	2020 оноос хойш үйлдвэрлэгдсэн шинэ байх шаардлагатай.
6	Техникийн үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>• Төмөр нэвтлэх чадвар нь 30мм-32мм</li> <li>• Төмөр утасны илрүүлэлт нь 36AWG-38AWG</li> <li>• Материал ялгах чадвар нь органик материалыг улбар шар, холимог материалыг ногоон, органик бус материалыг хөх өнгөөр харуулж чаддаг байх.</li> <li>• Генераторын хөргөлт нь битүүмжилсэн тосон хөргөлттэй байх.</li> <li>• Анодын хүчдэл нь 160 кВ</li> <li>• Хоолойн гүйдэл 0,9 мА</li> <li>• Рентген генераторын тусах өнцөг нь дээрээс доош диагналаар тусдаг байх.</li> <li>• Хадгалах температур нь -20°C-аас +60°C</li> <li>• Ажиллах температур нь 0°C-аас +40°C</li> </ul>
7	Техник ашиглалтын заавар	Тухайн төхөөрөмжийн сэлбэг нь суурилуулахад шаардлагатай өөрийн техник ашиглалтын гарын авлагатай байх ба англи хэл дээр заавартай байх.
8	Баталгаат хугацаа	Үйлдвэрлэгчийн ирүүлсэн баталгаат хугацаагаар
9	Дүрэм заавар	CE ба FCC, 21CFR 1020.40 ба ISO 9001:2000 бүлгийн стандартуудыг хангадаг байх шаардлагатай.
10	Брэндийн хувьд	Төхөөрөмжийн сэлбэг нь HEIMANN эсхүл түүнтэй дүйцэхүйц дэлхийд танигдсан нэйтэй брэндийн бүтээгдэхүүн байх шаардлагатай.

**Тав. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа/ DDP нөхцөл/		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Рентген цацрагийн генератор	Техникийн тодорхойлолтын үзүүлэлтийн шаардлагад нийцсэн	1	ширхэг	ИНЕГ	30 хоног	60 хоног	

## Зургаа. ЖИШИГ МАЯГТ

### 1. УНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга Л.Бямбасүрэн танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Тендер хүчинтэй байх хугацаа [хүчинтэй хугацааг заах] хоног байна.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал Үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Долоо. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |       |  |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших                             | 1.1.  | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1.  | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1.  | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1.  | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1.  | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат хугацаа 2 жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1.  | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1.  | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1.  | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1.  | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлтгэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Найм. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Барааны техникийн шаардлага тоо хэмжээг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор бараа, материал дээр хяналт хийсний дараа захиалагч барааг хүлээн авсанд тооцно.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.   |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Чанарын шаардлага бүрэн хангасан байна.   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний срөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>1. <b>Урьдчилгаа төлбөр:</b> Урьдчилгаа төлбөрийн дүн нь 30 % хүртэл хувь олгож болно. Урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү, ижил валютаар илэрхийлэгдсэн банкны батлан даалт буюу үл маргах нөхцөлтэйгээр банкнаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн төлбөрийг хийнэ.<br><br>2. <b>Бараа хүлээн авахад төлөх төлбөр:</b> Бараа ирснээс хойш нэхэмжлэх болон захиалагчийн хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үлдсэн төлбөрийг төлнө.<br><br>3. <b>Чанарын баталгаа:</b> Чанарын баталгаат хугацаа дууссаны дараа үлдсэн 5%-ийг ашиглагчын тодорхойлолтыг үндэслэн олгоно. Чанарын баталгааг үйлдвэрлэгчийн баталгаат хугацаагаар гаргана. |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | Гэрээний үнэ нь НӨАТ орсон үнэ болно.<br><br>9.1 Нийлүүлэгчид алданги оногдуулах хувь хоногт: <b>Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 %</b>  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх (ГЕН - 11)</b>                           | Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн <b>10%-иас хэтрэхгүй</b><br><br><b>11.1 Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</b>  |

## Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

### БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас *[захиалагчийн нэр]* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *[нийлүүлэгчийн нэр]* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь *[гэрээний нэр, дугаар]-г* (цаашид “бараа” гэх) *[гэрээний үнийг тоогоор болон үсээр]* (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх).  
Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]